



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.9, 29.1.10, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын “барих-шилжүүлэх” төрлөөр гэрээ байгуулсан “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэлд 167 км хатуу хучилттай авто зам барих” төслийн хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажлын хүрээнд гаргасан аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон акт, албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Үндэсний хөгжлийн газарт тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т даалгасугай.

3. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /Л.Оюун-Эрдэнэ/, Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Зам, тээврийн хөгжлийн сайд /Л.Халтар/, Үндэсний хөгжлийн газрын дарга /Б.Баярсайхан/-д тус тус зөвлөсүгэй.


4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /С.Оюунгэрэл/-т даалгасугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /ахлах аудитор Б.Болормаа/-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны
12 дугаар сарын 11-ны өдрийн 1/97 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



Аудитаар тогтоосон акт, албан шаардлагын жагсаалт

№	Төлбөр, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (сая төгрөг)		Төлбөр, зөрчил хариуцах	
		Акт	Албан шаардлага	Байгуул- лага	Албан тушаалтан
1	Концессын төслийн гэрээт ажлын гүйцэтгэл бүрэн хангагдаагүй байхад Улсын комисс "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын холбогдох заалтыг зөрчин авто замыг ашиглалтад хүлээн авсан		-	Зам, тээврийн хагжлийн яам	Сайд Л.Халтар
2	Авто замын барилга угсралтын ажлын зарим материалын орц, нормыг илүү тооцож баталгаажуулсан	84.1		Үндэсний хөгжлийн газар	Дарга Б.Баярсайхан
3	Концесс эзэмшигч нь гэрээнд заасан ажлыг дутуу гүйцэтгэсэн		7,818.2	Үндэсний хөгжлийн газар	Дарга Б.Баярсайхан
	Нийт дүн	84.1	7,818.2		



АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	3
Төслийн танилцуулга	4
Нэг. Төслийн гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулжээ.....	5
Хоёр. Концессын төслийн гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн байна.....	9
Гурав. Дүгнэлт.....	13
Дөрөв. Зөвлөмж.....	13
Хавсралт 1: Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл	14



Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АЗБХЗГ	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
БХТ	Барилгын хөгжлийн төв
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1.7 дахь хэсэгт "Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хөндлөнгийн аудит хийж, аудитын дүгнэлт гарах хүртэлх хугацаанд санхүүжилтийг түр хойшлуулах" гэж заасныг үндэслэн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны "Аудитын сэдэв батлах тухай" 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" А/53 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1¹, 6.3.3² дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт гаргах ажлыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

"Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын "барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт"-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад ажлын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлсэн болно. Үүнд:

- Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад хууль, эрх зүйн шаардлагыг хангасан төслийг тусгаж, концесс эзэмшигчийг хуулийн дагуу сонгон шалгаруулсан эсэх;
- Концессын төслийн гүйцэтгэл, түүнд тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх гэсэн дэд зорилтуудын хүрээнд гүйцэтгэв.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл, хамарсан хүрээ:

Дүгнэлт гаргах ажилд Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт (300), Төрийн аудитын стандарт MNS6817:2020, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан Сангийн яам, Үндэсний хөгжлийн газар, концесс эзэмшигч "Монгол ЛЗ зам гүүр" ХХК, зураг төсвийг зохиогч, магадлал хийсэн хуулийн этгээд, концесс эзэмшигч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг хамруулан, дээрх байгууллагуудаас төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой баримтуудыг гаргуулан авч, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах горимыг ашиглан нотлох зүйл цуглуулж, баримтжуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Хөрөнгө оруулалтын газраас /хуучин нэрээр/ 2016 онд концесс эзэмшигч "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай байгуулсан "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төсөл"-ийн гэрээний хэрэгжилтэд хийсэн аудитад хөндлөнгийн мэргэжлийн байгууллагыг шинжээчээр оролцуулж, концессын зүйлийн зураг төслийн боловсруулалт, баталгаажуулалт, зөвлөхийн хяналт, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн дүгнэлт гаргуулсан бөгөөд түүнд тулгуурлан аудитын үйл ажиллагааг хэрэгжүүллээ.

¹ шалгаагдагч этгээдэд ... санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудит хийх;

²төрийн санхүү, төсвийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд хуульд заасан болон шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар аудит хийх;



Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Концессын тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг;
- Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам";
- Төрийн өмчийн хороо (хуучин нэрээр)-ны 2010 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Концессын зүйлийн зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал";
- Сангийн сайдын 2016 оны 415, 2017 оны 273 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам";
- Засгийн газар болон "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-ийн хооронд 2016 онд байгуулсан "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төсөл"-ийн "барих-шилжүүлэх" концессын гэрээ;
- Авто замын салбарт мөрдлөг болгож буй норм, дүрэм, стандартууд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор С.Оюунгэрэл удирдаж, аудитын менежер Б.Саруул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Болормаа, аудитор М.Доржмаа, Ш.Наранбаатар нар гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

УИХ-ын 2008 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр"-ийн 2.4.31³-т тусгагдсан дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, авто зам, сүлжээг өргөтгөх ажлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр барихыг бүх талаар дэмжин ажиллах зорилтын хүрээнд Зам, тээвэр, барилга хот байгуулалтын яамнаас /хуучин нэрээр/ шинээр баригдах замуудын ирээдүйд гарах нийгэм эдийн засгийн ач холбогдол, төслөөс гарах зардал ашгийн тооцоо, судалгааг хийсэн байна.

Авто замын тухай хуулийн⁴ 3 дугаар зүйлийн 3.1.8-д "улсын чанартай авто зам" гэж "нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон авто замыг ойлгоно" гэж заасны дагуу Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлд баригдсан авто зам нь Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн замаас салж Завхан аймгийн Нөмрөг, Сонгино сумдын нутгаар дайран нийт 167 км үргэлжилсэн бөгөөд Тосонцэнгэл-Наранбулаг чиглэлийн замын сүлжээнд холбогдсоноор улсын чанартай авто замын ангилалд хамаарч байна.

Авто замын хөдөлгөөний эрчим нь тээврийн хэрэгслийн тоо, бараа ачаа эргэлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, шатахууны үнийн өсөлт бууралт зэргээс хамааралтай байдаг бөгөөд дээрх чиглэлийн 2010-2030 он хүртэлх авто замын хөдөлгөөний эрчмийн хэвийн өсөлтийн тооцоо, судалгаанд үндэслэн тухайн замын хэрэгцээ шаардлагыг тодорхойлжээ.

³Дэд бүтцийн хөгжлийг эрчимжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, үндэсний компаниудын чадавхыг дээшлүүлэх зорилгоор авто зам, төмөр зам, эрчим хүч, харилцаа холбооны сүлжээг өргөтгөх ажлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр барихыг бүх талаар дэмжинэ.

⁴2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болсон.



АУДИТЫН ДҮН

НЭГ. ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ХУУЛИЙН ДАГУУ СОНГОН ШАЛГАРУУЛЖЭЭ

Төслийн мэдээллийг төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан байна

1.1. Концессын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3⁵ дахь хэсэгт “Засгийн газар концессын зүйлийн жагсаалтыг батлахдаа дараах зүйлийг тусгана” гэж заасны дагуу Засгийн газрын 2013 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ын 11 дэх хэсэгт “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийг тусгасан байна.

Хүснэгт 1. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгасан төслийн мэдээлэл

Концессын зүйлийн нэр	Концессын зүйлийн тодорхойлолт	Концессын төрөл	Гүйцэтгэх ажил, үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр дэмжлэг үзүүлэх эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах эсэх
“Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг- Сонгино чиглэл”-д 167 км хатуу хучилттай авто зам барих төсөл 11.1. 50 км авто зам 11.2. 50 км авто зам 11.3. 67 км авто зам	Завхан аймгийг Увс аймагтай холбох авто замын сүлжээний хэсэг бөгөөд аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох	Барих-шилжүүлэх	Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх	Судлан шийдвэрлэх	Уралдаант шалгаруулалт явуулах

Эх сурвалж: Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралт

1.2. Ийнхүү дээрх шийдвэрийн дагуу “барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг- Сонгино чиглэл”-д 167 км хатуу хучилттай авто зам барих төсөл”-ийн концесс эзэмшигчийг уралдаант шалгаруулалт явуулж сонгохоор баталжээ.

Уралдаант шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулсан байна

1.3. “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замын төсөл”-ийн уралдаант шалгаруулалтыг Эдийн засгийн хөгжлийн сайдын /хуучин нэрээр/ 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 13 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс зарлаж, хуулийн этгээдээс ирүүлсэн саналыг 2014 оны 7 дугаар сарын 03-ны өдөр нээхэд уг төсөлд нэг ч хуулийн этгээд санал ирүүлээгүй байна.

1.4. Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т⁶ заасны дагуу Хөрөнгө оруулалтын газрын даргын /хуучин нэрээр/ 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/004 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгээс гаргасан концесс эзэмшигчтэй шууд гэрээ байгуулах тухай дүгнэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.

1.5. Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т “концесс олгох шийдвэр гаргаж, концессын гэрээ байгуулах эрхийг ... байгууллагад олгох” гэж заасны дагуу Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн “...концессын гэрээ байгуулах эрх олгох тухай” 226 дугаар тогтоолоор “Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төсөл”-ийн концессын гэрээг “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-тай байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/-т олгожээ.

⁵ 10.3-т Концессын зүйлийн жагсаалтад дараах зүйлийг тусгана:

10.3.1-д концессын зүйлийн нэр, тодорхойлолт, концессын төрөл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ;

10.3.2-т төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх;

10.3.3-д энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан уралдаант шалгаруулалт явуулах, эсхүл шууд гэрээ байгуулах эсэх.

⁶ “Уралдаант шалгаруулалт зарласан боловч санал ирээгүй, эсхүл шаардлагад нийцсэн санал ирээгүй бөгөөд уралдаант шалгаруулалт дахин зарласан ч шаардлагатай хугацаанд санал ирэх магадлал бага гэж эрх бүхий этгээд үзсэн”



1.6. Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/-аас 2016 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн "Дүгнэлт хүргүүлэх тухай" 01/264 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэл"-ийн 167 км хатуу хучилттай авто замын төслийн хөрөнгө оруулалтыг 662.4 сая юаниар тооцоолсон талаарх мэдээллийг хүргүүлсэн байна.

1.7. Ийнхүү Засгийн газрын 2016 оны 226 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Хөрөнгө оруулалтын газар /хуучин нэрээр/ "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх 662.4 сая юантай тэнцэх төгрөгийн үнийн дүнтэй концессын гэрээг "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай 2016 оны 7 дугаар сарын 19-ний өдөр байгуулжээ⁷.

1.8. Гэвч Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн "Концессын төслүүдийн талаар авах арга хэмжээний тухай" 37 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт заасны дагуу эдийн засаг, төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан "Концессын гэрээ байгуулсан боловч ажил нь эхлээгүй гэрээний үйлчлэлийг зохих журмын дагуу зогсоох" гэж шийдвэрлэж, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг ЗТХЯ дээр байгуулагдсан байна.

1.9. Үүний дагуу Үндэсний хөгжлийн газраас 2016 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр концесс эзэмшигч "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-д 01/57 дугаар албан бичгээр ЗТХЯ дээр байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэгдсэний дараа танай компани болон хуучнаар Хөрөнгө оруулалтын газартай байгуулсан ... концессын гэрээг цааш нь үргэлжлүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэх болно" гэсэн мэдэгдэл хүргүүлсэн байна.

1.10. Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, концессын гэрээгээр хэрэгжүүлж байгаа авто замын төслүүдийн талаар ЗТХЯ-аас танилцуулсны дагуу концессын гэрээ байгуулсан боловч барилга угсралтын ажил нь эхлээгүй байгаа Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто замын барилгын ажлыг эхлүүлэх хугацааг хойшлуулж, концессын эргэн төлөлтийн төлбөрийг 2021 оноос эхлэн төлөхөөр төлөвлөн хэрэгжүүлэх" гэж шийдвэрлэжээ.⁸

1.11. Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн "Концессоор хэрэгжүүлэх авто замын төслүүдийн талаар авах арга хэмжээний тухай" 84 дүгээр тогтоолын 5 дахь хэсэгт "Засгийн газрын 2016 оны 226 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн "662,453.581 юантай тэнцэх төгрөг" гэсэн төслийн төсөвт өртгийг "660,017,006 юань" гэж өөрчилж, концессын гэрээнд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Үндэсний хөгжлийн газарт даалгасан байна.

1.12. Дээрх өөрчлөлтийн үндэслэлийг хянаж үзэхэд "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэл"-ийн 167 км хатуу хучилттай авто замын төслийн гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн хөрөнгө оруулалтаас концесс эзэмшигчийн хүртэх ашгийг 2.4 сая юаниар бууруулжээ. Үүнд:

Хүснэгт 2. Гэрээний үнийн тооцоолол /юань/

Барилга, угсралтын ажлын зардал	Зөөлөхийн хяналтын зардал	Даатгалын хураамж	Дүн	Зээлийн хүү	Ашиг	Нийт дүн
1	2=1*5 %	3=1+2*4%	4=1+2+3	5	6=(1+2)*9.5%	7=4+5+6
464,109,256.00	23,205,462.80	19,492,588.80	506,807,307.60	106,914,803.00	46,294,898.30	660,017,008.80

Эх сурвалж: Концессын гэрээний хавсралт

⁷ Концессын гэрээний 1.17-д "Гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс гэрээ байгуулагдсанд тооцох..."

⁸ Загийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ний өдрийн хуралдааны 63 дугаар тэмдэглэл



1.13. Концессын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2, 22.3⁹, 23 дугаар зүйлийн 23.1¹⁰ дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны "Концессоор хэрэгжүүлсэн авто замын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 84 дүгээр тогтоолын 6 дахь заалт болон концессын гэрээний 6 дугаар бүлэгт заасныг үндэслэн Концессын гэрээнд дөрвөн удаа дараах нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан байна. Үүнд:

2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр:

- Концессын гэрээний нийт хөрөнгө оруулалт буюу гэрээний үнийн буюу 1.6-д "662,453,581.00 гэснийг 660,017,006.00 юань;
- Төслийг ашиглалтад оруулах хугацааг буюу гэрээний 1.8-д "Концессын зүйлийг концесс эзэмшигч нь ашиглалтад хүлээлгэн өгсөн өдрөөс хойш түүний баталгаат хугацаа 3 жил байна" гэснийг "Концессын зүйлийг концесс эзэмшигч нь ашиглалтад хүлээлгэн өгсөн өдрөөс хойш түүнийг зүгшрүүлэх хугацааг 1 жил, баталгаат хугацаа 3 жил байна" гэж тус тус өөрчилсөн.
- Төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн хуваарь буюу гэрээний 1.10 дахь хэсэгт эргэн төлөлтийн төлбөр хийх хугацааг 1 жилээр хойшлуулсан байна.

2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр:

- Концессын зүйлийг ашиглалтад оруулах хугацааг буюу гэрээний 1.7 дахь хэсгийн "2018 он" гэснийг "2019 он" гэж нэг жилээр хойшлуулсан;
- Гэрээний хугацаа талууд гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш "6 жил" байна гэснийг 7 жил байхаар өөрчилсөн;
- Мөн 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний 1.2-т "Концесс эзэмшигч нь концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр санхүүжүүлэн, барьж дуусган холбогдох хууль тогтоомжийн дагуу хүлээлгэн өгч, төсөлд оруулсан хөрөнгө оруулалтаа 4 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас доорх хуваарийн дагуу нөхөж авна" гэсэн заалтыг нэмсэн байна.

2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр:

- Концесс эзэмшигчийн хүсэлтээр гэрээний 1.11-д заасан дансны "5116015546" гэсэн дугаарыг "5124038915" гэж өөрчилжээ.

2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр:

- Концессын гэрээний 1.10-т заасан хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн эхний ээлжийн санхүүжилтийг "2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө" гэснийг "2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө" гэж өөрчлөн найруулсан байна.

1.14. Ийнхүү концессын гэрээнд 2017-2020 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний үнийн дүн, санхүүжилтийн эргэн төлөлтийн хуваарь, төслийг ашиглалтад оруулах хугацаатай холбоотой заалтууд байна.

1.15. Концессын гэрээнд 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр концессын гэрээ хэрэгжиж эхэлсэн байна.

Концесс эзэмшигч гэрээний урьдчилсан нөхцөлүүдийг хангасан байна

1.16. Концессын гэрээний 1.18¹¹-д заасны дагуу Үндэсний хөгжлийн газарт гүйцэтгэгч ААН-ээс /2017 оны 8 дугаар сарын 01-ний өдөр/ дээрх урьдчилсан нөхцөлүүд бүрэн хангагдсан талаар 2017/136 дугаартай албан бичиг ирүүлсэн буюу гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлд заасан хугацааг 3 сараар хоцроосон байна.

⁹ 22.1. Концессын гэрээний хугацааг тухайн салбарын онцлог, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, түүнийг нөхөх хугацаа, олох ашиг, концессын зүйлийн ашиглалтын хугацаа зэргийг харгалзан гэрээний талууд тохиролцоно.

22.2. Дор дурдсан тохиолдолд концессын гэрээний хугацааг эрх бүхий этгээд сунгана:

22.2.1. гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хойшлогдсон;

22.2.2. төрийн байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу концессын гэрээнд заасан үйл ажиллагаа тасалдсан, хой 22.2.3. эрх бүхий этгээдийн концессын гэрээнд тусгагдаагүй хүсэлт, шаардлага нь концесс эзэмшигчийн зардлыг өсгөхөд хүрээсэн бөгөөд концесс эзэмшигч гэрээний хугацааг сунгалуугаар тухайн зардлыг нөхөх боломжгүй болсон.

22.3. Концесс эзэмшигчид санхүүгийн үр дагавар үүсгэх, эсхүл нийтэд хэт өндөр үнэ тариф, төлбөр ногдуулахад хүргэх урьдчилан тооцоогүй нөхцөл байдал үүссэн үед концессын гэрээг эрх бүхий этгээд сунгаж болно.

¹⁰ 23.1-т "Гэрээний талууд харилцан тохиролцож концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно".

¹¹ "...Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 2 сарын хугацаанд ...урьдчилсан нөхцөл бүрэн хангагдсанаар энэхүү Гэрээ хүчин төгөлдөр болно.



1.17. Үндэсний хөгжлийн газраас 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдөр концессын гэрээний хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлийг хянасан тухай дүгнэлт гарган, "гэрээний 1.18.1-1.18.1.4 дэх заалтууд бүрэн биелэгдсэн" гэж дүгнэж¹² гэрээг хүчин төгөлдөр болсныг 2017 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр 01/830 дугаартай албан бичгээр гүйцэтгэгчид мэдэгджээ.

1.18. Концессын гэрээ хүчин төгөлдөр болох шаардлагыг хэрхэн хангасныг авч үзвэл,

Хүснэгт 3. Концессын гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлийг хангасан байдал

Концессын гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөлүүд	Хэрэгжүүлсэн байдал	Шаардлагыг хангасан эсэх
1.18.1. Төслийн барилга угсралтын зардлын 5 хувьтай тэнцэх 25,340,365.38 юань МУ-ын арилжааны аль нэг банкин дахь өөрийн дансанд байршуулж төслийн зориулалтын дагуу зарцуулж эхэлсэн байх	Голомт банкны гүйцэтгэлийн баталгааны хугацааг 6 сараар буюу 2018.01.31-ний өдөр хүртэл сунгасан	Нотлох баримт ирүүлсэн
1.18.2. Авто замын хяналтын зөвлөх компанийн зардал 23,205,462.80 юань Эрх бүхий этгээдийн заасан дансанд тушаасан байх	хэрэгжүүлсэн	Нотлох баримт ирүүлсэн
1.18.3. Барилгын ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байх /Монголын үндэсний ААН-тэй барилгын ажлын 1/3-аас доошгүй хувийн ажлыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байх/	Монголын ААН-тэй барилгын ажлын 1/3-аас доошгүй хувийн ажлыг гүйцэтгүүлээгүй	Нотлох баримт ирүүлээгүй
1.18.4. Концесс эзэмшигч нь гадаадын ААН байгаа тохиолдолд, ... концесс эзэмшигчийн 100 хувийн хөрөнгө оруулалттай компанийг байгуулсан байх. Тус компани нь концесс эзэмшигчтэй адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ.	хэрэгжүүлсэн	Нотлох баримт ирүүлсэн

1.19. Ийнхүү концесс эзэмшигч "Монгол ЛЗ зам гүүр" ХХК концессын гэрээний 1.18.1-1.18.4 хэсэгт заасан гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийг бүрэн хангасан гэж ҮХГ дүгнэснээр гэрээ хүчин төгөлдөр болсон байна.

Төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлжээ

1.20. Концессын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт "барих-шилжүүлэх" концесс гэж "концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх" гэж заасан байна.

1.21. "Монгол ЛЗ зам гүүр" ХХК төслийн хөрөнгө оруулалтыг БНХАУ-ын "Bank of China" болон "Export import bank of China"-аас Хятадын төв банкнаас зарласан "benchmark rate"-ыг 110 хувиар өсгөн хүү төлөхөөр 429.0 сая юанийн зээлжих эрхийн гэрээ байгуулан зээл авч, авто замын барилгын ажлыг гүйцэтгэсэн байна.

1.22. Концессын гэрээнд төсөлд оруулсан хөрөнгийн эргэн төлөлтийг 4 жилд хуваан олгохоор тусгасан бөгөөд "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-аас 2017 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 2017/11 дугаартай албан бичгээр төслийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг дараах хуваарийн дагуу авах талаар саналыг Үндэсний хөгжлийн газарт ирүүлжээ.

1.23. Концессын гэрээнд 2017 оны 3 дугаар сарын 30-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хөрөнгө оруулалтын санхүүжилтийн эргэн төлөлтийг 2020-2023 онуудад олгохоор тусгасан байна. Үүнд:

Хүснэгт 4 Эргэн төлөлтийн шинэчилсэн хуваарь

Гэрээний эргэн төлөлтийн хуваарь /сая юань/		Төсвийн тухай хуулиар /сая.төгрөг/		Төлбөр гүйцэтгэх хугацаа	Тайлбар
мөнгөн дүн	ханш	Төсвөт өртөг	санхүүжих дүн		
165.0	381.00	251,466.5	62,866.6	2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө	Гэрээний 1 дүгээр зүйлийн 1.11-т "...эргэн төлөлтийг тооцохдоо тухайн өдрийн Монгол банкны зарласан ханшаар хөрвүүлэн тооцно".
165.0			62,866.6	2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө	
165.0			62,866.6	2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө	
165.0			62,866.6	2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө	
Нийт дүн 660.0					

Эх сурвалж: ҮХГ концесс эзэмшигчийн хооронд байгуулсан концессын нэмэлт гэрээ

¹² "Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох урьдчилсан нөхцөл хангагдсан эсэх талаар Эрх бүхий этгээд дүгнэлт гаргана".



1.24. Гэрээний 1.14-т "концесс эзэмшигч эргэн төлөлтийн хуваарийн дагуу нөхөн олговроо аваагүй тохиолдолд санхүүжүүлэгч тал баримтаар нэхэмжилсэн тохиолдолд алдангийн асуудлыг харилцан тохиролцож шийвэрлэнэ" гэж заасан байна.

1.25. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх "барих-шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн эргэн төлөлтийн жагсаалт"-д төслийн төсөвт өртөг 251,466.5 сая төгрөгөөс хөрөнгө оруулалтын эргэн төлөлтөд 2020 онд 62,866.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тусгажээ.

ХОЁР. КОНЦЕССЫН ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

Авто замын зураг төсөл нь холбогдох хууль, тогтоомж, стандарт, норм, дүрмийн шаардлагыг хангасан байна

2.1 "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэл"-ийн 167 км хатуу хучилттай авто замын зураг төсөл, ажлын тоо хэмжээг Авто замын газрын даргын 2012 онд баталсан баталсан *10/11 дугаартай* зургийн даалгаврын дагуу "Аврага зам" ХХК-ийн зургийн инженер Н.Чинтөгс боловсруулж, эксперт Я.Баярхүү хянаж, Барилгын хөгжлийн төвийн 2013 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 009/2013 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр хянаж баталгаажуулсан байна.

2.2 Төслийн зураг төсөл боловсруулсан "Аврага зам" ХХК-ийн тооцсон ажлын тоо хэмжээг үндэслэн Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын /хуучин нэрээр/ 2007 оны 186 дугаар тушаалаар батлагдсан "Төмөр бетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм", "Авто замын барилгын төсвийн жишиг норм"-ыг баримтлан авто замын нийт төсөвт өртгийг 2018 онд мэргэшсэн төсөвчин Д.Энхцэцэг 149,529.8 сая төгрөг буюу 487.2 сая юаниар үнэлсэн байна¹³.

2.3 Үндэсний хөгжлийн газраас 2018 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэл"-ийн 167 км хатуу хучилттай авто замын төсөвт магадлал хийлгэж ирүүлэх тухай 01/479 дугаартай албан бичгийг "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-д мэдэгдсэний дагуу концесс эзэмшигч 2018 оны 5 дугаар сарын 8-ны өдөр тус авто замын төсөлд магадлал хийлгэх хүсэлтийг ЗТХЯ-ны харьяа Зам, тээврийн хөгжлийн төвд 102 дугаартай албан бичгээр гаргажээ.

2.4 Дээрх хүсэлтийг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн төв болон "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-ийн хооронд 2018 оны 5 дугаар сарын 28-ны өдөр "Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлын гэрээ" байгуулагдсаны дагуу төслийн төсвийг тэргүүлэх төсөвчин Д.Энхтуяа 149,529.8 сая төгрөгөөр тооцож, "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн 98/2018 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан байна.

2.5 Магадлалын ерөнхий дүгнэлтэд "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэл"-ийн 167 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлын төсвийг холбогдох норм, дүрмийн шаардлагад нийцүүлэн зохиосон, төсвийн тооцоо нь "Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын дагуу боловсруулагдсан гэжээ.

¹³ ЗГ-ын 2016 оны 226 дугаар тогтоолоор "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км авто зам төсөл"-ийн концессын гэрээг "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай байгуулах эрхийг Хөрөнгө оруулалтын газарт олгосон тул төслийн төсөвт өртгийг Монгол банкны 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн /1 юань=306.86/ ханшаар хөрвүүлж тооцсон байна.



2.6 Аудитаар төслийн төсөвт өртөг холбогдох хууль, тогтоомж, стандарт, жишиг, норм, үнэлгээний дагуу үнэн зөв зохиогдож, хянагдсан эсэх асуудлыг тулган баталгаажуулахад авто замын барилга угсралтын ажлын зарим материалын орц, нормыг 84.1 сая төгрөгөөр илүү тооцож баталгаажуулсан тул зөрчлийг арилгуулж, төсвийн орлого болгох тухай төлбөрийн акт бичигдсэн.

2.7 Төслийн барилгын ажилд техник, технологийн хяналтыг хэрэгжүүлсэн "Эм Си Пи Си Жи Ар" ХХК авто замын зураг төсөлд тусгагдсан 179 цэгт баригдахаар төлөвлөгдсөн хоолойны зарим цэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсний дагуу төслийн зургийг боловсруулсан "Аврага зам" ХХК-ийн зүгээс 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 143 дугаар албан бичгээр зургийн инженерийн сонголт, шийдэл болон холбогдох тайлбарыг¹⁴өгч ажиллажээ.

2.8 Авто замын барилгын зураг төслийн төлөвлөлт болон бүтээцийн шийдэл нь авто замын салбарт хүчин төгөлдөр мөрдөж буй норм дүрэм, стандарт, инженер геологийн дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу төлөвлөгдсөн, зураг төсөл нь норм дүрэм, стандартын шаардлагыг хангасан байна.

Авто замын чанар байдлын ерөнхий үзүүлэлтүүд хангагдсан байна

2.9 Концессын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4.3-т "Концесс эзэмшигч нь гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний чанар, тоо, хэмжээг концессын гэрээнд заасан хэмжээнээс бууруулахгүй байх" гэж заасан байна.

2.10 "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэлд 167 км хатуу хучилттай авто зам барих төсөл"-ийн концессын гэрээний 2.1 дэх хэсэгт "Эрх бүхий этгээд нь батлагдсан зураг төслийн дагуу барилгын ажилд хяналт тавих хяналтын зөвлөх компани ажиллуулна" гэж заасан байна.

2.11 Тус төслийн зам барилгын ажилд хяналт тавьж ажиллах байгууллагаар авто замын зөвлөх үйлчилгээний "Эм Си Пи Си Жи Ар" ХХК шалгарч, Үндэсний хөгжлийн газартай 5,413.4 сая төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээг 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр байгуулж, авто замын үе шатны ажлын тайланг гаргаж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна.

2.12 Үндэсний хөгжлийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-иас 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдөр Үндэсний хөгжлийн газарт шилжүүлсэн "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэлд 167 км хатуу хучилттай авто зам барих төсөл"-ийн техникийн хяналтын зардлаас хэмнэгдсэн 2,986.9 сая төгрөгт төлбөрийн акт тогтоон, улсын төсвийн орлого болгосон байна.

2.13 Концессын гэрээний 2.16 дахь хэсэгт заасны дагуу концесс эзэмшигч байгууллагаас ирүүлсэн хүсэлтэд үндэслэн ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 344 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 15-ны өдрүүдэд барилга угсралтын ажлын талбайд ажиллан 2020 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 10/15/19 дугаартай дүгнэлтээр авто замыг байнгын ашиглалтад оруулах шийдвэр гаргасан нь "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын холбогдох заалттай нийцэхгүй байна.

¹⁴ ПК 15+860 дээрх хоолойн усны зарцуулалтын тооцоогоор хос байхаар төлөвлөсөн боловч эцэслэн зурагт тусгахдаа Ф1.0 гэж техник алдаа гаргасан тул Ф1.0х2 болгох; мөн шинээр нэмж 3 цэгт Ф1.0м огтлол бүхий хоолойг Ф1.5х2х2 болгох, зохиогчийн хяналтын шатанд газар дээр нь үзэж шийдвэр гаргах боломжтой гэжээ.



2.14 Аудитад хөндлөнгийн шинжээчээр ажилласан "Танил санаа" ХХК-ийн шинжээчдийн баг тус "... авто замын техник-ашиглалтын түвшин тодорхойлох хэмжилт, туршилтын ажлыг авто замын салбарт мөрдөж буй стандарт, норм дүрэм, аргачлалыг баримтлан гүйцэтгэсэн байна" гэж дүгнэжээ.

2.15 Шинжээчдийн багийн хэмжилт судалгааны ажлын үр дүнгээр "гүйцэтгэгч барилга угсралтын ажлыг өөрийн машин механизм, хүчин чадал үйлдвэрлэлийн баазад тулгуурлан 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн бөгөөд ажлын үе шат бүрийг зөвлөхийн өдөр тутмын хяналтаар баталгаажуулсан байна" гэж дүгнэж, авто замын чанар байдлын түвшнийг тогтоон, үнэлгээ өгч, барилга угсралтын ажлын гүйцэтгэлд давтан хэмжилт судалгааны ажлыг хийсний үндсэн дээр "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэл"-д баригдсан 167 км хатуу хучилттай авто замын чанар байдлын ерөнхий үзүүлэлтийг "хангалттай" гэж үнэлсэн байна.

2.16 "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-ийн гүйцэтгэсэн авто замын барилга угсралтын ажлын тоо хэмжээг төслийн техникийн шаардлага, батлагдсан зураг төсөвтэй тулган баталгаажуулахад дараах ажлууд дутуу хийгдсэн байна. Үүнд:

- Авто замын хучилтын зузаан хангалтгүй, 120 м хэсэг техникийн шаардлагад нийцээгүй,
- Улсын байцаагчийн албан шаардлага болон чанар байдлын дүгнэлтээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж зөвлөхөөрөө хянуулаагүй;
- Төмөр бетон гүүрүүдийн хэв гажилтын заадсыг техникийн шаардлага, зургийн дагуу бүрэн хийгээгүй;
- Төмөр бетон хоолой, гүүрийн орох, гарах амсрын шороог бүрэн зайлуулаагүй, тэмдэглээг хийх, голдрил засах ажлыг бүрэн хийгээгүй;
- 167 км замын трассын дагуу хийгдсэн 352 ширхэг босоо тэмдгийн суурийг цемент бетоноор бэхлэх;
- Гарц зогсоол, уулзваруудын чулууны ялгаралт их байгаа бөгөөд асфальбетон хучилтыг дахин хийх шаардлага үүссэн;
- Хөвөөний нягт байдлыг техникийн шаардлагад нийцүүлэх;
- Далангийн хажуу налуу, шуудууг зураг төслийн болон техникийн шаардлагад бүрэн нийцээгүй, авто замын шороон гарцуудыг бүрэн хаагаагүй;
- Хэв хашмалын илүү арматур, гүүрийн ус зайлуулах цоргыг таслаагүй;
- Дутуу нөхөн сэргээсэн карьеруудын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийгээгүй зэрэг ажлууд дутуу байна.

2.17 Концесс эзэмшигчийн зүгээс дээрх дутуу хийсэн ажлыг гүйцэтгэх төлөвлөгөөг гарган төслийн захиалагч болон авто замын хяналтыг хэрэгжүүлэгч зөвлөх байгууллагаар хянуулж баталгаажуулсан боловч дэлхий нийтэд тархаад буй Корона вирусын /Covid-19/ халдварын улмаас Монгол Улс, БНХАУ хоорондын авто зам, төмөр зам болон агаарын замаар нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбоотойгоор төслийн ерөнхий инженер болон инженер техникийн ажилтнууд төлөвлөсөн ажлаа хугацаандаа гүйцэтгэх боломжгүй байдал үүссэн байна.

2.18 Аудитаар "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэл"-д 167 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 5. Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл /юань/

Концессын гэрээний дүн	ҮХГ-ын хянасан гүйцэтгэл	Дутуу хийсэн ажлын дүн /албан шаардлага/	Аудитаар хянасан гүйцэтгэл	Санхүүжүүлэх дүн
1	2	3	4	5=3+4
660,017,006.00	640,360,845.00	19,656,161.00	640,360,845.00 *	660,017,006.00

Эх сурвалж: Хөндлөнгийн шинжээчийн тайлан

Тайлбар: *Энэ гүйцэтгэлийн дүнд авто замын барилга байгууламжийн угсралтын ажлын төсөвт зарим материалын орц, нормыг алдаатай тооцооноос үүссэн 84.1 сая төгрөгийн төлбөрийн актын дүн орсон болно.

2.19 Концессын гэрээнд хамаарах нийт ажлаас үлдсэн 7,818.2 сая төгрөгийн үнэлгээ бүхий барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах талаар Үндэсний хөгжлийн газар болон концесс эзэмшигчид аудитаар албан шаардлага хүргүүлээ.



Авто замын төслийг хэрэгжүүлснээр зам ашиглалтын зардал буурах эдийн засгийн шууд болон шууд бус үр өгөөж гарч байна

2.20 "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг Сонгино чиглэлд 167 км хатуу хучилттай авто зам барих төсөл"-ийн төлөвлөлтийн үеийн судалгааны тайлангаас үзэхэд төслийн хүрээнд баригдсан зам нь ердийн хөрсөн зам байсан бөгөөд тухайн үеийн олон улсын индексийн үзүүлэлттэй харьцуулахад энэ замаар авто машинаар зорчиход тааламжгүй нөхцөлтэй, дунджаар 3.5 м-ийн өргөнтэй байсан гэж тодорхойлж байжээ.

2.21 Салбарын яамнаас төслийг хэрэгжүүлэхээс өмнө буюу тухайн замд ямар нэгэн хөрөнгө оруулалт хийгдээгүй байх үеийн зам ашиглалтын байдлыг төсөл хэрэгжүүлсний дараах зам ашиглалтын байдалтай харьцуулсан судалгаагаар төслийн санхүүгийн болон санхүүгийн бус үр өгөөж, нийгэм эдийн засгийн ач холбогдол илэрхийлэгдэж байна.

2.22 Улсын хэмжээнд 2010 оны байдлаар авто замын сүлжээгээр зорчиж буй ачаа, зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн мэдээллийн санг үүсгээгүй байсантай холбоотой улсын чанартай авто замуудын хөдөлгөөний эрчмийг тухай үеийн болон хэтийн 10 жилийн төлөвийн шинжилгээнд тулгуурлан ЗТХЯ-ны харьяа Авто замын газраас 2019 онд ашиглалтад орсон замуудын эдийн засгийн үр өгөөжийг тооцжээ. Тухайлбал,

- *Авто зам ашиглагчдын зам ашиглалтын зардал буурснаар хөдөлгөөний эрчим нэмэгдэж, шинээр бий болж буй хөдөлгөөний олон удаагийн давтамжаар зам ашиглагч нарын туулж буй зай, км, зорчигчдын тав тух сэтгэл ханамжийн үзүүлэлтээр илэрхийлэгдсэн;*
- *Төсөл хэрэгжсэн бүс нутагт дэд бүтэц сайжирснаар орон нутгийн бүтээн байгуулалт нэмэгдэх, аялал жуулчлал хөгжих нөхцөлийг бүрдүүлжээ.*

2.23 Тус газраас хийсэн тооцоогоор хатуу хучилттай авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлснээр гарах үр ашиг нь зам ашиглалтын үед гарах зардлыг багасах, /шатахуун, засвар үйлчилгээ/, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдал хангагдаж, тээвэрчид болон тээврийн хэрэгслээр зорчигчдын цаг хугацааг хэмнэх, улмаар хүний эрүүл мэндэд учрах сөрөг нөлөөг бууруулах эдийн засгийн бус шууд үр өгөөж гарах боломжтой гэжээ.

Хүснэгт 6. Төслийг хэрэгжүүлснээр гарах үр өгөөж

Авто замын чиглэл	Замын урт /км/	Тээврийн хэрэгслийн хурд		Зам туулах хугацаа	
		Төслийн өмнө дундаж хурд км/ц	Төслийн дараа дундаж хурд км/ц	Төслийн өмнө /цагаар/	Төслийн дараа /цагаар/
Тосонцэнгэл-Улиастай	181	35-40	80-100	4.5	2.3
4 зам-Нөмрөг-Наранбулаг-Улаангом	490	35-40	80-100	12.3	6.1

Эх сурвалж: Олон улсын болон орон нутгийн чанартай авто зам барих төслийн нийгэм эдийн засгийн тайлан/

2.24 Тус замын ашиглагч байгууллагаар "Завхан" АЗЗА ТӨХК 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн ажиллаж байгаа ба тухайн зам, замын байгууламжийн ашиглалтын үеийн чанар байдлын талаар аудитын багт ирүүлсэн албан бичигт "цас их хунгарладаг газруудыг дурдаж, зам, замын байгууламжийн барилга угсралтын ажилтай холбоотой аливаа чанарын гологдол гарч, эвдрэл үүссэн зүйл одоогоор гараагүй байна" гэжээ.



ГУРАВ. ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн уралдаант шалгаруулалтыг хуулийн дагуу зохион байгуулжээ.
- Төслийн зураг төсөл барилгын салбарт мөрдөгдөж байгаа норм, дүрэм, зургийн даалгавар, техникийн нөхцөлийн шаардлагыг хангасан бөгөөд эрх бүхий байгууллагаар хянагдаж магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан байна.
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд төслийн төсөвт өртөг 251,466.5 сая төгрөгөөс эргэн төлөлтөд гэрээний дагуу 62,866.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тусгасан байна.
- Концессын төслийн гэрээт ажлын гүйцэтгэл бүрэн хангагдаагүй байхад Улсын комисс "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам"-ын холбогдох заалтыг зөрчин авто замыг ашиглалтад хүлээн авсан байна.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт:

- Төслийн санхүүжилтийн эргэн төлөлтийг концессын гэрээнд заасан хуваарийн дагуу олгох арга хэмжээ авах.

Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд:

- "Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг холбогдох хууль журамд нийцүүлэн санхүүжүүлэх.
- Авто замын чанар байдлын дүгнэлтэд тусгагдсан болон Улсын комиссоос өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан, актаар хүлээн авах ажлыг зохион байгуулах.



Хавсралт 1

Концессын зүйлийн хөрөнгө оруулалтын төсөв, гүйцэтгэл

/юаны/

Зардлын төрөл	Гэрээний үнэ	Гүйцэтгэл /УХГ/	Гүйцэтгэл /Аудитаар/	Дутуу хийсэн ажлын дүн /албан шаардлага/	Санхүүжүүлэх дүн
Барилга, угсралтын ажлын дүн	413,697,579.00	398,711,555.00	395,828,341.45	14,986,024.00	410,814,365.45
НӨАТ	41,369,758.00	39,871,155.50	39,582,834.15	1,498,602.50	41,081,436.65
Зөвлөх үйлчилгээ	23,204,297.00	23,204,297.00	23,204,297.00		23,204,297.00
Магадалшгүй ажил	8,273,952.00	5,129,392.00	8,273,952.00	3,144,560.00	11,418,512.00
Норм, нормативын сан	744,656.00	717,681.00	744,656.00	26,975.00	771,631.00
ДҮН	487,290,242.00	467,634,080.50	467,634,080.60	19,656,161.50	487,290,242.10
Даатгалын зардал	19,492,589.00	19,492,589.00	19,492,589.00	-	19,492,589.00
Зээлийн хүү	46,319,374.27	46,319,374.27	46,319,374.27	-	46,319,374.27
Хөрөнгө оруулалтын ашиг	106,914,801.17	106,914,801.17	106,914,801.17	-	106,914,801.17
ДҮН	660,017,006.44	640,360,844.94	640,360,845.04¹⁵	19,683,136.50	660,017,006.54

¹⁵ Санхүүжүүлэх дүнгээс авто замын барилга угсралтын ажлын материалын орц, нормыг илүү тооцсон 84,138,051.00 төгрөг хасагдах болно..